МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17 Факс: (976-51) 26 24 08.
Цахим шуудан: info@cabinet.gov.mn.
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.12.09 № Хэг/2457

танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 10 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

0002450249

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024.11.22 № А1/2031

танай _____-ны №_____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.СОЛОНГОО ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгатай холбогдуулан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

132008285

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 11 сарын 28-нөдрийн
А/1/2037 тоотай албан бичгийн хавсралт

**Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагааны талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгатай холбогдуулан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээлэл**

***1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн өр төлбөрийг хэрхэн бууруулах, хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар***

2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг төвлөрсөн бус байдлаар буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (түүний харьяанд - 31), Сангийн яам (түүний харьяанд - 7), Эрчим хүчний яам (түүний харьяанд - 34), Зам, тээврийн яам (түүний харьяанд - 4), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (түүний харьяанд - 4), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (түүний харьяанд - 31), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (түүний харьяанд - 21) зэрэг 7 өөр төрийн захиргааны байгууллагуудаас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж удирдлага, зохицуулалтаар хангаж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс харьяа 21 байгууллагын өр төлбөрийг бууруулах, үйл ажиллагааг сайжруулах талаар дараах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Чиг үүргийн давхардалтай, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг, үр ашиггүй төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах зэргээр өөрчлөн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2022-2024 онуудад өөрийн харьяанд байсан 2 үйлдвэрийн газрыг татан буулгасан, 7 үйлдвэрийн газрыг нэгтгэж 3 болгосон, 20 авто замын засвар арчлалтын нэгтгэл компанийг нэгтгэн 1 болгосон. Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлснээр манай байгууллагын харьяанд байсан 32 компани, үйлдвэрийн газрыг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгах замаар 4 болгон бууруулаад байна.
- Харьяа 14 төрийн өмчит үйлдвэрийн газар, 5 төрийн өмчит компаниудын тухайн жилийн санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг орлого, үр ашгийг нэмэгдүүлэх, зардал, авлага, өглөгийг бууруулах, өгөөжтэй хөрөнгө оруулалт хийх бодлогыг баримтлан баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр цахимаар хүлээн авч дүн шинжилгээ хийн, хангалтгүй байгаа компани, үйлдвэрийг газруудад санхүү, эдийн засгийн үзүүлэлт бүрээр тухай бүрд нь чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн ТӨБЗГ-с хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй төрийн өмчийн оролцоотой 2 компани байгаа ба тус 2 компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг батлахдаа хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, удирдамжийн дагуу орлого, үр ашгийг нэмэгдүүлэх, зардал, авлага, өглөгийг бууруулах чиглэл өгч

ажилладаг. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр цахимаар хүлээн авч дүн шинжилгээ хийн, хангалтгүй байгаа эдийн засгийн үзүүлэлт бүрээр тухай бүрд нь чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

- Харьяанд буй 5 төрийн өмчит компани, 2 төрийн өмчийн оролцоотой компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд компанийн үр ашиг, үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангаж ажиллах талаар удирдамжийг тухай бүрд нь хүргүүлж ажилласан.

***2. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй этгээдээс томилж буй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн шалгуур, боловсрол, ажлын туршлага, тэдгээрийн тайлан, үнэлгээ***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяа 100% төрийн өмчит 5 компани, төрийн өмчийн оролцоотой 2 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын гуравдугаар зүйл "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага", дөрөвдүгээр зүйл "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх", тавдугаар зүйл "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах" зэрэг заалтууд болон компанийн дүрмийн дагуу 2024 онд төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх 31 гишүүдийг томилж, чөлөөлсөн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн хувь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяа 100% төрийн өмчит 5 компани, төрийн өмчийн оролцоотой 2 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн Компанийн тухай хуулийн 77, 79 дүгээр зүйл, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам"-ын гуравдугаар зүйл "Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага" зэрэг зүйл, заалтууд болон компанийн дүрмийн дагуу 2024 онд төлөөлөн удирдах зөвлөлийн 12 гишүүдийг томилж, чөлөөлсөн.

"Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээний нийт 36 асуулгатай тайлангаар 2023 оны байдлаар "Монгол шуудан" ХК 80.5%, "Монголын цахилгаан холбоо" ХК 98.6%-ийн үнэлгээтэй гарсан.

***3. Төрийн өмчит хуулийн этгээдийн ажилтнуудын тоо болон дундаж цалин, сүүлийн жилүүдийн өөрчлөлтийн талаар***

Нийт ажилтнуудын тоо 2011-2023 он

| Он | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Тоо | 40,294 | 40,611 | 45,189 | 45,595 | 45,610 | 45,539 | 45,800 |
| Өөрчлөлтийн хувь | - | 0.8% | 11.3% | 0.9% | 0.03% | (0.15%) | 0.6% |

| Он | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Тоо | 45,800 | 43,830 | 43,990 | 50,331 | 53,255 | 56,896 | 58,087 |
| Өөрчлөлтийн хувь | 0.6% | (4.3%) | 0.37% | 14.4% | 5.8% | 6.8% | 2.1% |

Нийт цалингийн сан болон сарын дундаж цалингийн судалгаа 2021-2023 он

Сая төгрөг

| Он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|
| Нийт цалингийн сан | 1,279,195.48 | 1,499,728.7 | 2,157,835.4 |
| Сарын дундаж цалин | 2.0 | 2.2 | 3.1 |
| Өөрчлөлтийн хувь | - | 10% | 41% |

***4. Ирэх 4 жилд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит компаниудын жагсаалт болон түүнд бариmтлах шалгуур үзүүлэлтүүдийн талаар***

Албан ёсоор Улсын Их Хурлаас ирэх 4 жилд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит компаниудын жагсаалтыг батлаагүй байна.

***5. Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 244 дүгээр тогтоолуудад нэр дурдагдсан төрийн өмчит компаниудын 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдах ажил бүрэн хэрэгжүүлээгүй шалтгаан, цаашид авах арга хэмжээний талаар***

Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаар

| № | Компани, үйлдвэрийн газрын нэр | Хэрэгжилт |
|---|---|---|
| 1 | "Төрийн банк" ХК | Төрийн банк нь нийт хувьцааныхаа 5.71%-ийг олон нийтэд нээлттэй арилжиж 7,306 хувь хүн, аж ахуйн нэгжийн 67.3 тэрбум төгрөг буюу 22.1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 3 дахин өндөр дүнтэйгээр давж биелэн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан. |
| 2 | "Монголын хөрөнгийн бирж" ХК | Монголын хөрөнгийн бирж нь нийт хувьцааныхаа 34%-ийг олон нийтэд нээлттэй арилжиж 7,414 хувь хүн, аж ахуйн нэгжийн 57.8 тэрбум төгрөг буюу 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зарласнаас 4.8 дахин өндөр дүнтэйгээр давж биелэн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан. |
| 3 | "Үндэсний давхар даатгал" ХХК | Мэргэжлийн байгууллагуудаас Үнэт цаасны танилцуулгыг бэлэн болгож, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс анхдагч зах зээлийн арилжааг хийх зөвшөөрөл олгосон боловч зөвшөөрлийн хугацаандаа анхдагч зах |

| | | |
|---|---|---|
| 4 | "Монголын цахилгаан холбоо" ХК | зээлийн арилжааг эхлүүлж чадаагүй үндсэн шалтгаан нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно." гэж заасны дагуу хөрөнгө оруулагч нь дангаар болон холбогдох этгээдийн хамт нийт хувьцааны 5% болон түүнээс дээш хувийг эзэмшихийг хуулиар хориглосонтой холбоотой байна. |
| 5 | "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК | "Мэдээлэл, холбоо сүлжээ" ТӨХХК нь стратегийн дэд бүтэц эзэмшигч компани, тул IPO гаргах жагсаалтаас хас ч өөр хэлбэрээр олон нийтийн хяналтын зохистой оролцоог бий болгохоор төлөвлөж байна. |
| 6 | "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ | "Мэдээлэл, технологийн үйлдвэрийн парк" ТӨҮГ нь салбарын инновац, инкубатор төв тул IPO гаргах жагсаалтаас хас ч өөр хэлбэрээр олон нийтийн хяналтын зохистой оролцоог бий болгохоор төлөвлөж байна. |
| 7 | Авто замын засвар арчлалтын 20 компани | Авто замын засвар арчлалтын 20 төрийн өмчит компаниудыг нэгтгэж "А33А нэгтгэл" компани байгуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 153 дугаар тогтоолоор 20 А33А компанийн 8 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар зогсоож, компаниудыг А33А нэгтгэл ТӨХК-ийн охин компанийн хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэж 2025 оны 01 дүгээр сараас охин компаниудыг толгой компани уруу нийлүүлж 1 компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж эхэлнэ. Цаашид А33А нэгтгэл ТӨХК-ийн хэмжээнд IPO гаргахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. |

Цаашдын санал:

Тухайн компанийн нийт хөрөнгө, үйл ажиллагааны цар хүрээ, салбарын онцлогийг харгалзан стратегийн хөрөнгө оруулагч буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувь хэмжээ /5%/-г оновчтой тогтоох;

Статусыг өөрчлөх, бүтцийг оновчтой болгох, өр төлбөрийг цэгцлэх, орлого, үр ашгийг нэмэгдүүлэх замаар компанийн хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх;

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа компаниудыг нэгтгэх, өөрчлөн зохион байгуулах эсвэл засаглал, үр ашиг, олон нийтийн хяналтыг сайжруулах өөр хэлбэрийг сонгох.

Банкнуудын IPO-той холбоотойгоор Монголын хөрөнгийн биржийн багтаамжийг харгалзан үзэж хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд арилжих цаг хугацааг дахин авч үзэх шаардлагатай байна.

***6. Засгийн газраас баримталж байгаа Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх бодлого болон төр оролцохгүй бизнесийн бизнесийн чиглэл, хувийн хэвшлийн гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээг хэрэгжүүлж буй төрийн өмчит компаниудын мэдээлэл, эдгээрийн талаар цаашид авах арга хэмжээний талаар***

Засгийн газраас Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримтлан 2022 оны 340 дүгээр тогтоол гарсан. Тус тогтоолын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

**Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилт**

1. Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээний хүрээнд гүйцэтгүүлж байгаа болон цаашид үе шаттай нэмж гүйцэтгүүлэх боломжтой чиг, үүрэг ажил үйлчилгээ. Үүнд:

А/ Гэрээний хүрээнд шилжүүлсэн чиг үүрэг

"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ

- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ,
- Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалт эрхлэх чиг үүргийг "Монголын барилгачдын нэгдсэн холбоо" ТББ,
- Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох чиг үүргийг "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ,

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ

- Мэргэшсэн жолоочийн сургалт зохион байгуулах чиг үүргийг 30 гаруй сургалтын байгууллагаар,
- Авто тээврийн хэрэгсэлд техник хяналтын үзлэг хийх чиг үүргийн хүрээнд 12 оношилгооны төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 9-ийг хувийн хэвшлийн байгууллага гүйцэтгэж байна,

"Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК

- Биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох чиг үүргийг ТББ-д шилжүүлэх, Биржийн байнгын гишүүн брокеруудыг сургах, мэргэшүүлэх ажлыг гүйцэтгүүлэх
- Биржийн байнгын бус гишүүн хоршоодыг сургах, чадавхжуулах ажлыг гүйцэтгүүлэх

"Монгол шуудан" ХК

- Шуудангийн транзит тээврийн үйлчилгээ
- Орон нутгийн шуудан тээврийн үйлчилгээ

"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ

- Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны 112 нэр төрлийн ажлуудыг хувийн хэвшил, ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Авто замын засвар арчлалтын төрийн өмчит компаниуд

- Авто зам засвар арчлалтын үйлчилгээ /12 хувийн хэвшлийн компаниудад гэрээгээр гүйцэтгүүлж байна/

Б/ Гэрээний хүрээнд цаашид үе шаттай нэмж шилжүүлэх чиг үүрэг

Дараах төрийн өмчит хуулийн этгээдийн зарим чиг үүргийг 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах байдлаар хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр үе шаттай гүйцэтгүүлэхээр холбогдох бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. Үүнд:

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ

- Орон нутагт ачаа тээврийн зориулалт бүхий терминал, логистикийн төв болон зам дагуух цогцолбор, түр амрах цэгийг байгуулах, түүний үйлчилгээ

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК

- Орон сууцны хотхон, хорооллын ашиглалтын үйл ажиллагаа
- Төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууцны хотхон, хорооллын борлуулалтын авлагыг төвлөрүүлэх үйл ажиллагаа
- "Төрийн түрээсийн орон сууцны сан"-д шилжүүлсэн орон сууцуудын түрээсийн авлага төвлөрүүлэх үйл ажиллагаа.

"Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК

- Стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторид итгэмжлэл олгох чиг үүргийг хэрэгжүүлэх.

"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ

- Төлбөр авах цэгийг цахимжуулах ажил

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК

- Цахилгаан түгээх сүлжээ болон "Хэрэглэгчдэд үйлчлэх төв" (ХҮТ)-ийн ажил, үйлчилгээ

2. Худалдан авах ажиллагааны хүрээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж буй ажил, үйлчилгээ, худалдан авч буй бараа материал:

Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нь үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг ханган явуулахад

шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт зарлан сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих журмын дагуу хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ирсэн. Жишээлбэл 2022 онд урсгал зардал, хөрөнгө оруулалтын хүрээнд 7 их наяд орчим төгрөгийн 5496 ширхэг бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байна. Ажил, үйлчилгээ, бараа материал худалдан авах ажиллагааг ангилал, төрлөөр нь багцлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Технологийн барилга байгууламж, байр, сууц, агуулахын барилга барих, шинэчлэх, засварлах үйлчилгээ
2. Зураг төсөл, төсөв зохиох
3. Катерингийн үйлчилгээ
4. Бүх төрлийн даатгалын үйлчилгээ
5. ТЭЗҮ, туршилт, судалгаа, үнэлгээ, аудитын үйлчилгээ
6. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны тоног төхөөрөмж, машин, механизмын засвар, шинэчлэлт, тохируулга, суурилуулалтын үйлчилгээ
7. Мэдээлэл, технологи, программ хангамжийн үйлчилгээ
8. Машин, механизм, оффис түрээсийн үйлчилгээ
9. Ажлын хувцас, ХАБЭА хэрэгсэл
10. Худаг сувагчлал, шилэн кабель, цамхаг барих үйлчилгээ
11. Харуул хамгаалалтын үйлчилгээ
12. Хэвлэмэл бүтээгдэхүүн, хэвлэх үйлчилгээ
13. Эрүүл мэндийн үйлчилгээ
14. Барилга байгууламж болон ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээ
15. Төмөр замын засвар, арчлалтын үйлчилгээ
16. Нөхөн сэргээлтийн үйлчилгээ
17. Бүх төрлийн сургалтын үйлчилгээ
18. Хууль болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ
19. Уул уурхайн олборлолт
20. Өрөмдлөг, тэсэлгээний үйлчилгээ
21. Шатахуун, шатах тослох материал
22. Үйлдвэрлэл, үйл ажиллагаанд шаардлагатай бүх төрлийн машин, механизм, тоног төхөөрөмж, багаж, сэлбэг хэрэгсэл
23. Үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай түүхий эд, бараа материал
24. Компьютер, техник, тоног төхөөрөмж
25. Бичиг хэрэг, дагалдах хэрэгсэл
26. Тавилга, эд хогшил
27. Бүх төрлийн тээврийн үйлчилгээ
28. Эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт

**Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд цаашид анхаарах асуудлууд:**

- Төрийн өмчит 6 компани, үйлдвэрийн газрын 11 чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр шилжүүлсэн. Цаашид 12 нэр төрлийн чиг үүрэг, ажил үйлчилгээг гүйцэтгүүлэх боломжтой байна. Мөн 2022 оны байдлаар 7 их наяд орчим төгрөгийн төсөвт өртөгтэй 5496 ширхэг 28 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны хүрээнд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлсэн байна.
- Цаашид төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компаниудын тодорхой үйл ажиллагааны чиглэлийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх цар хүрээг өргөтгөх, төр хувийн хэвшлийн ажил хэрэгч түншлэлийг бий болгох хүрээнд үйлдвэрийн газар, компани нэг бүрийн эрхэлж буй үндсэн болон туслах үйл ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээнд чиг үүргийн шинжилгээ хийн, нарийвчилсан тооцоо судалгаа гаргаж, үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүрэг, ажил, үйлчилгээг үзүүлж буй байгууллага нь хараат бус, ил тод нээлттэй, мэргэжлийн түвшинд ажил, үйлчилгээг үзүүлж байгаа эсэх, тухайн салбарын нийтлэг ашиг сонирхлыг төлөөлж буй чадамж зэргийг харгалзан сонгон шалгаруулах, гэрээ байгуулах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, хариуцлагын тогтолцоо бүхий эргэх механизмыг төлөвшүүлэх;
- Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлээр гүйцэтгүүлж буй ажил, үйлчилгээний цар хүрээг өргөтгөж, гэрээг урт хугацаанд тогтвортой мөрдөн ажиллах нөхцөлийг хэвшүүлэх нь зохистой байна.

***7. Төрийн өмчит компаниудын сүүлийн 5 жилийн дотоод аудит, хөндлөнгийн аудитаар илэрсэн зөрчил, ашиглан, шамшигдуулалт, тэдгээрийн мөрөөр авсан арга хэмжээний талаар***

Холбогдох аудитын байгууллагаас төрийн өмчит компаниудын талаар аудитаар илэрсэн зөрчил, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээллийг авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс харьяа байгууллагуудын аудитын тайлангаар илэрсэн зөчрил, дутагдлыг тухай бүрд нь засч залруулах, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа болно.

***Ирүүлсэн асуулгатай холбоотой нэмэлт мэдээллүүд:***

Төрийн өмчит компаниудын удирдлага, зохицуулалт, хяналт, үнэлгээг сайжруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Компани бүрийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд дахин шинэчлэн боловсруулах.
- Богино хугацааны төлөвлөлт буюу зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хянах асуудлыг боловсронгуй болгох, ангилалд тохируулан оновчтой тогтоох.
- Төсвийн шинжтэй зардал санхүүжүүлэхгүй байх, шаардлагагүй нийгмийн хариуцлагын шинжтэй санхүүжилтийг зогсоох.

- Компаниудын зардлыг бууруулж, ашгийн үзүүлэлт, санхүүгийн чадавх, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, төрийн өмчит компаниудын хоорондын өр төлбөрийн асуудлыг цэгцлэх, түргэн барагдуулахад анхаарах.
- Бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулж, ажилтнуудын тоог зохистой түвшинд байлгах.
- Захирлын гэрээ байгуулах, дүгнэх асуудлыг олон улсын түвшинд хүргэж, оновчтой болгох.
- Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хүрээнд хувийн хэвшилд шилжүүлэх чиг, үүрэг ажил, үйлчилгээг компаниудын 2024 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгах.
- Компаниудын санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн цахим сан бий болгох.
- Дотоод аудитын, хяналтын тогтолцоог сайжруулах.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн хүрээнд цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд хийгдэж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах,
2. Төрийн өмчийг хувьчлах өөрчлөн байгуулах чиглэлээр гарсан Улсын Их Хурлаас гаргасан тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, холбогдох санал дүгнэлт боловсруулах, тухайн компанийг хувьчлах, хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй худалдах асуудлыг компани бүрийн ажлын цар хүрээ, өмчлөлийн онцлог, хэлбэрийг харгалзан нарийвчлан тогтоох
3. Төрийн өмчит компанийн засаглал, өмчлөлийн бодлогыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд олон улсын хөгжлийн байгууллагуудтай (OECD, EBRD, ADB гэх мэт) хийгдэж байгаа яриа хэлэлцээрийг эцэслэн хамтын ажиллагааг өргөн хүрээнд эхлүүлэх.
4. Олон улсын хөгжлийн байгууллагуудаар Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын талаар хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх, тайлан зөвлөмж гаргуулах, үнэлгээний хүрээнд Төрөөс төрийн өмчийн салбарт баримтлах бодлогын нэгдсэн баримт бичгийг боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдүүлэх.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах ажлыг олон улсын хөгжлийн байгууллага болон бусад улс орнуудыг туршлагад нийцүүлэн зохион байгуулах.
   Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх ажлыг олон улсын жишигт нийцүүлэх.

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

---oooOOOooo---